



**ТӨВ АЙМГИЙН
ЗУУНМОД СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2023 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/309

Зуунмод

Г Дайчилгаатай сургалтад хамруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Засгийн газрын 2019 оны 462 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Дайчилгааны сургууль явуулах тухай журам”-ын 1.2 дахь хэсэг, Засгийн газрын 2022 оны мн/306 дугаар тогтоол, Төв аймгийн Засаг даргын 2023 оны мн/04 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЛАХ нь:

1.Зуунмод сумын нутаг дэвсгэрт цэргийн “Дайчилгаатай болон орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн хамтатгасан сургууль”-ийг 2023 оны 09 дүгээр сарын 08-12-ныг хүртэл хугацаанд зохион байгуулах тул нэгдүгээр зэргийн томилгоот нэгжийн бэлтгэл үүрэгтнийг 1 дүгээр хавсралтаар, дэг журам сахиулахад дэмжлэг үзүүлэх тасаг, гамшиг хөнөөх хэрэгслийн нөлөөлөлтэй тэмцэх тасгийг 2 дугаар хавсралтаар, сэтгэл зүйн хангалтын бүлгийг 3 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Батжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Ч.САРАЦГЭРЭЛ

